

ҮАГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлан

2004 оны 6 дугаар сар

Тендерийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна

Тендерийн холбогдолтой хууль
тогтоомжийн хэрэгжилтэд
хийсэн аудит

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	5
Аудитын дүн	Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгцээ шаардлагын талаар	6
	Бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгосон байдал	8
	Төсвийн хөрөнгийн зарцуулалтад арвилан хэмнэлт, үр ашиг, ил тод байдал бий болсон эсэх	16
	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний ашиглалт үр дүн	18
	Хуулийн хэрэгжилтэд тавьж буй хяналт болон өмнөх шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлтийг шалгасан тухай	20
Дүгнэлт		23
Холбогдох байгууллагын санал	Санхүү, эдийн засгийн яамны санал	24
	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны санал	27
	Дэд бүтцийн яамны санал	30
	Эрүүл мэндийн яамны санал	31
Зөвлөмж		32

Агуулга

Тайланд гарах товчилсон үгс

СЭЗЯ	Санхүү эдийн засгийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ДБЯ	Дэд бүтцийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2002 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 9/7299 дүгээр албан бичиг, Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд тендерийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлыг хамруулан шалгаж дүгнэлт гарган, зөрчил дутагдал илэрвэл түүнийг арилгах, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- ❖ Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгцээ шаардлага
- ❖ Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгосон байдал
- ❖ Төсвийн хөрөнгийн зарцуулалтад арвилан хэмнэлт, үр ашиг, ил тод байдал бий болсон эсэх
- ❖ Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний ашиглалт, үр дүн

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль (цаашид “хууль” гэх) нь төрийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох зорилгоор тендерийн бичиг баримт боловсруулах, зарлан мэдээлэх, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох, болон тендерийн хорооны бүтэц, зохион байгуулалт, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Дээрх хуулийн 3 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр тодорхой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шийдвэр гарсны дараа түүний гүйцэтгэгчийг сонгох, гэрээ байгуулах, хүртлэх үйл ажиллагаанд энэ хууль үйлчлэхээр заасан байна.

Аудитыг СЭЗЯ, БСШУЯ, ДБЯ, ХХААЯ, ЭМЯ болон түүний харъяа зарим агентлаг, байгууллагуудын 2003 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой баримт материалд тулгуурлан явууллаа.

Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн БСШУЯ-ны “Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх”, “Нийгмийн эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд зэрэг сурдаг өрхийн хүүхдэд үнэ төлбөргүй олгох хичээлийн хэрэглэл нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон байдлыг СЭЗЯ-ны худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтэст хүсэлт тавьж шалгуулан дүгнэлтийг албан ёсоор гаргуулан

Ерөнхий зүйл

авсны гадна тус хэлтсээс нэг мэргэжилтнийг Багануур ХК-д тендерийн хуулийн хэрэгжилтийг шалгах ажилд татан оролцууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Тендерийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг шалгаж дүгнэлт гаргах аудитын зорилттой уялдуулан аудитын явцад мөрдөж ажиллах шалгуур үзүүлэлт, аудитын горимыг аудитын төлөвлөгөөний хавсралт хэлбэрээр батлуулан аудитын явцад мөрдөж ажиллав.

Аудитад дараахь шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгцээ шаардлагын талаар
 - Захиалагч батлагдсан төсөвтэй уялдуулан тухайн жилийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх график, төлөвлөгөө буюу хуваарь, худалдан авах ажиллагааны явцын тайланг “Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам” (цаашид “Тусгай журам” гэх)-ын 2-т заасны дагуу гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулсан эсэх
 - Захиалагч нь тухайн жилд худалдан авах бараа, ажлын жагсаалтыг өдөр тутмын болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан эсэх
2. Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгосон байдал
 - Тендерийн хороо, үнэлгээний хэсгийг хуулийн 38 дугаар зүйлд заасан нөхцөл, шалгуурыг харгалзан зохион байгуулсан эсэх, тендерийн хорооны эрх, үүргийн биелэлт
 - Гүйцэтгэгч сонгох ажиллагааны журмыг хуулийн 9.1-д заасан босго үнийг баримтлаж зөв сонгосон эсэх
 - Тендерийн бичиг баримтыг хуулийн 13 дугаар зүйл, Тусгай журам-ын 33-39-д заасан тендерийн бичиг баримтын бүрдэл болон бусад нөхцөл, шалгуурыг харгалзан бэлтгэж, тендерийн хороогоор баталгаажуулсан эсэх
 - Тендерийн бичиг баримтын үнийг үндэслэлтэй зөв тогтоосон эсэх
 - Захиалагчид тусгай журмын 9 дүгээр бүлэгт зааснаар худалдан авах ажиллагаа тус бүрт бичиг баримтын бүрдлийн хавтаст хэрэг нээж хөтлөн архивийн нэгж болгон хадгалсан эсэх
 - Тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах хүртлэх үйл ажиллагаа хууль, тогтоомжийн холбогдох заалтын дагуу явагдсан эсэх.
3. Төсвийн хөрөнгийн зарцуулалтад арвилан хэмнэлт, үр ашиг,

Ерөнхий зүйл

ил тод байдал бий болсон эсэх

- Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлснээр түүнд зарцуулсан хөрөнгө анх төлөвлөж байсан хэмжээнээс буурсан эсэх.

4. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний ашиглалт, үр дүн

- Гүйцэтгэгч захиалагчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байдал
- Худалдан авах ажиллагааны үр дүн захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч байгууллагуудын ашиг сонирхлыг хангаж байгаа эсэх

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримталж ажилласны гадна Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх аудитын хөтөлбөр, шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн Төрийн төв байгууллагын багийн аудитор, шинжээчид 2004 оны 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 21-нийг хүртлэх хугацаанд хийлээ.

Аудитын дүн

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгцээ шаардлагын талаар

Захиалагч байгууллагууд Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор баталсан “Бараа ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”-ын (цаашид “Тусгай журам” гэх) 2 дугаар бүлэгт заасны дагуу тухайн жилийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх график, төлөвлөгөөнд тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр тендерийн хороо байгуулах, тендерийн бичиг баримт бэлтгэж, батлуулах, тендерийн урилгыг зарлан мэдээлэх, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх зэрэг ажлуудыг хэзээ, хэн, яаж хэрэгжүүлэхийг тодорхойлох ёстой.

Худалдан авах ажиллагааны явцын тайланд худалдан авах ажиллагааны хөрөнгийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны сонгосон журам, тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах, бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх хугацаа, тэдгээрийн санхүүжилт зэрэг ажлыг хэзээ, хэн, яаж хэрэгжүүлсэн байдлыг тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр тодорхойлсон байх ёстой.

Аудитад хамрагдсан 19 байгууллагын 93,7 хувь буюу 15 байгууллага тухайн жилд худалдан авах бараа, ажлын төслийг баталж, холбогдох шийдвэр гарсны дараа уг төлөвлөгөөтэй уялдуулан худалдан авах ажиллагааны график, төлөвлөгөө, явцын тайланг гаргаж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь худалдан авах ажиллагааны явцыг тайлагнах, нэгтгэн зохион байгуулах, худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтнуудын үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас шалтгаалжээ.

Энэ байдлаас болж аудитад хамрагдсан байгууллагуудын хуулийн дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэр, батлагдсан төсөв, гүйцэтгэл зэрэг худалдан авах ажиллагааг хэрхэн хэрэгжүүлсэн талаархи мэдээллүүдийг худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл тус бүрээр гаргаж авахад хүндрэл учруулж байлаа.

Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх ажлын явц, цаг хугацаа, хүн хүчний асуудлыг нарийн төлөвлөхгүй байгаагаас тендер шалгаруулалт цаг хугацааны хувьд давхардах, тендерийг хуульд заасан хугацаанд зарлах боломжгүй болж, тендер шалгаруулалт зарлалгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хууль зөрчих, тендерт оролцогчдын тендерт оролцох боломжийг тэр хэмжээгээр хязгаарлах, захиалагч хэрэглэгчдэд хүргэх бараа, ажил, үйлчилгээг цаг хугацаанд нь өгч чадахгүй байх зэрэг нөхцөл бүрдэж худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэвийн явуулах нөхцөл боломжийг алдагдуулж байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг цаг хугацааны хувьд

Аудитын дүн

хэрэгцээ шаардлагатай нь уялдуулан хийж, оновчтой зохион байгуулаагүйгээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээний чанар, нийлүүлэлтийн байдалд сөргөөр нөлөөлж иржээ.

Тухайлбал:

- ЭМЯ-наас тарваган тахлын вакцин нийлүүлэх тендерийг хугацаа алдаж зарласнаас уг вакцин нь хугацаа хожимдож нийлүүлэгдэн энэ нь онцгой нөхцөл байдал бий болсон үед бэлэн биш байгааг харуулж байна.
- Улсын клиникийн төв, Клиникийн II, III, Гэмтэл, согог сэргээн засах эмнэлгүүд нь тендер зарлах хугацааг төлөвлөгөөтэй зохион байгуулаагүйгээс оны эхний 1-5 сарын хугацаанд эм, эмнэлгийн хэрэгслийг тендергүйгээр бэлтгэжээ.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн эх бэлтгэх, хэвлэх тендер шалгаруулалт төсөв батлагдсанаас хойш 5 сарын дараа зарлагдсаны зэрэгцээ БНХАУ-д хийлгэх явдал нийтлэг байна. Улсын гаалийн ерөнхий газрын 2004 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 10/1732 дугаар албан бичгээр ирүүлсэн 2003, 2004 онд БНХАУ-аас импортолсон сурах бичгийн талаархи мэдээнээс үзвэл 2003 онд Мөнхийн үсэг ХХК 5, 6 дугаар ангийн Монгол хэл, 7, 10 дугаар ангийн Газар зүй, Адмон ХХК 7, 8 дугаар ангийн Геометр, Шувуун саарал ТӨҮГ 2 дугаар ангийн Орон нутаг зэрэг сурах бичгийг БНХАУ-д хэвлүүлэн импортолсон байна.

Энэ нь худалдан авах ажиллагааны үндсэн зарчмын нэг болох “дотоодын гүйцэтгэгч, үйлдвэрлэгчдийг дэмжих” гэсэн зарчим алдагдахад хүрч байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг өөрийн оронд үйлдвэрлэх боломжгүй болгож БНХАУ-д хэвлүүлэхэд хүргэж байгаа нь сурах бичгийг хэвлэх явцад технологийн болон чанар, эрүүл ахуйн хяналт хийгддэггүй, сурах бичгийн эх зохиолыг бэлтгэж, бэлэн болгох ажлыг хугацаа алдаж зохион байгуулснаас шалтгаалжээ.

Энэ байдал жил бүр давтагдсаар байхад БСШУЯ түүний холбогдох албан тушаалтнууд тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

- ХХААЯ ургамал хамгааллын арга хэмжээнд батлагдсан хөрөнгөнөөс 503 га-д үлийн цагаан оготно, царцаа устгах 223,8 сая төгрөгийн химийн хор худалдан авахаар төлөвлөж, 181,8 сая төгрөгөөр оготно, царцаа устгах хорыг худалдан авч хэрэглэсэн байна. Гэтэл 1997 оноос Даян дэлхийн байгаль орчныг хамгаалах сан, НҮБХХ-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой хөгжлийн арга зам” төсөл, Дэлхийн байгаль хамгаалах сангийн

Аудитын дүн

Монгол дахь хөтөлбөрийн газрын эрдэмтэн судлаачид “манай улсад сүүлийн 40 орчим жил хэрэглэж буй үлийн цагаан оготныг устгах химийн арга нь эцсийн үр дүн муутай, эдийн засгийн хувьд үрэлгэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, экологийн хувьд буруу арга” гэж дүгнэсэн байна. Тэд оготной тэмцэх гол арга бол бэлчээрийн талхагдлаас сэргийлэх, зүй зохистой ашиглах бодлогын арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэх явдал юм гэж үзжээ. Дэлхий нийтэд үлийн цагаан оготно устгахад хэрэглэдэг химийн бодис “Бромациолон”-ыг хүн, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үзэж маш багаар ашигладаг юм байна.

Захиалагч байгууллага нь тусгай журмын 12 дугаар зүйлд зааснаар тухайн жилд худалдан авах бараа, ажлын жагсаалтыг өдөр тутмын болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэх ёстой.

Аудитад хамрагдсан 19 байгууллагын 94,7 хувь буюу 18 байгууллага тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалтыг гаргаж нийтэд мэдээлээгүй байна.

Энэ нь худалдан авах ажиллагааны ил тод байх үндсэн зарчим бүрэн хэмжээгээр хангагдахгүй байгааг харуулж байна.

Бараа, ажил,
үйлчилгээний
гүйцэтгэгчийг
сонгосон
байдал

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2003 онд худалдан авсан 68615,0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон байдлыг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан аудитын горим, шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан шалгалаа.

Дээрх худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 7776,3 сая төгрөгийг төсвийн урсгал зардлаас, 32866,7 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 27972.1 төгрөгийг бусад эх үүсвэрээс тус тус санхүүжүүлжээ.



Нийт худалдан авалтын 51,3 хувь буюу 35,2 тэрбум төгрөгийн

Аудитын дүн

бараа, ажил, үйлчилгээг нээлттэй, 5,8 хувь буюу 4,0 тэрбум төгрөгийг тусгайлсан, 2,1 хувь буюу 1,4 тэрбум төгрөгийг харьцуулсан, 40,8 хувь буюу 27,8 тэрбум төгрөгийг шууд гэрээ байгуулах болон гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэхээр тус тус худалдан авсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд нийт худалдан авалтын 22,5 хувь буюу 15,5 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг хууль зөрчиж, тендер зарлалгүй худалдан авсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд гүйцэтгэгч сонгох ажиллагааны журмыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгосон эсэхийг холбогдох баримт материалд тулгуурлан шалгалаа.

Захиалагч байгууллагууд хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д заасан төсөвт өртгийг харгалзан гүйцэтгэгч сонгох ажиллагааны үндсэн журам болох нээлттэй тендер шалгаруулалт, гүйцэтгэгч сонгох ажиллагааны онцгой журам болох хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аль нэгийг сонгож худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.

Аудитад хамрагдсан байгууллагууд зарим худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч сонгох ажиллагааны журмыг дээрх хуулийн заалтын дагуу сонгож хэрэгжүүлээгүй байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэж худалдан авах ёстой 11,2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг хязгаарлагдмал тендер шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах аргаар худалдан авсан нь аудитад хамрагдсан нийт худалдан авалтын 16,3 хувийг эзэлж байна.

Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг хэрэглэж худалдан авах ёстой 4,3 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах буюу нэхэмжлэхийг үндэслэж худалдан авсан нь аудитад хамрагдсан нийт худалдан авалтын 6.2 хувийг эзэлж байна

Энэ нь хуулийн 6 дугаар зүйлийн 1-д заасан “Энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасан онцгой журам хэрэглэх нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гүйцэтгэгч сонгох ажиллагааг 3 дугаар бүлэгт заасан нээлттэй тендер шалгаруулалтын журмыг үндэслэн явуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал:

- Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 16 дугаар тушаалаар тус яамны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон сууц худалдан авахад зориулж 285.2 сая төгрөгийг Монголбанкнаас авсан хүүгийн урамшууллын орлогоос зарцуулахыг зөвшөөрсний дагуу Баянгол дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан орон сууцны 4 давхар барилгыг

Аудитын дүн

- “Солонго бил” ХХК-аар 285.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсан,
- Багануур ХК “Нисээч Интернэшнл” ХХК-наас TEREX 3307W маркийн Усны автомашиныг 349.7 сая төгрөгөөр, “Комит” ХХК-наас Коматцу 1093 маркийн өөрөө буулгагч автомашиныг 104.0 сая төгрөгөөр, “Чандмань транс” ХХК-наас Краз 257 маркийн өөрөө буулгагч автомашиныг 30.0 сая төгрөгөөр тус тус шууд гэрээ хийж худалдан авсны гадна үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох дизелийн түлшийг 12 компаниас шууд гэрээгээр худалдан авахад 4269.4 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь тус компанийн аудитад хамрагдсан нийт худалдан авалтын 16.1 хувийг эзэлж байна.
 - ХХААЯ 2,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шүлхийн вакцин, оношлуур нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2003 оны 1 дүгээр сард зарлаж, 2 дугаар сарын 20-нд гэрээ байгуулсан байхаар төлөвлөсөн боловч ХХААЯ-наас СЭЗЯ-нд 2002 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн албан бичиг нь санхүүжилтийн санал, графикийн уялдаа зөрүүтэй зэргээс шалтгаалан 2003 оны 2 дугаар сарын 11-нд Тендерийн хороо байгуулах СЭЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаал гарч, хугацаа бага гэсэн үндэслэлээр тусгайлсан тендерээр шалгаруулахаар тендерийн хороо шийдвэрлэсэн байна. Мөн Ургамал хамгааллын бараа нийлүүлэх 244,8 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг хугацааны өмнө нийлүүлэх шаардлагыг харгалзах гэсэн үндэслэлээр хязгаарлагдмал хэлбэрээр зарлажээ.

Аудитад хамрагдсан байгууллагууд гүйцэтгэгч сонгох ажиллагааны журмыг холбогдох хуулийн заалтын дагуу сонгож хэрэгжүүлэхгүй байгаа нь худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг хэрэгцээ шаардлагатай уялдуулан төлөвлөөгүйгээс нээлттэй тендер шалгаруулах хугацаагүй болсноос гадна дээрх жишээнд дурдсан байгууллагууд нээлттэй тендер шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн 27 дугаар зүйлийн 1-д заасан шууд гэрээ байгуулах нөхцөл байдал бий болоогүй байхад хууль зөрчиж шууд гэрээ байгуулсан байна.

Тендерийн үйл ажиллагааг хангалтгүй зохион байгуулснаас хугацаа алдаж, цаг хугацаанд шахагдах нь хуулинд заагдсан тендерийн хэлбэрийг дур мэдэн өөрчлөх үндэслэл болох учиргүй гэж үзэж байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2003 онд зарласан тендерийн материалд тулгуурлан тендерийн бичиг баримтын боловсруулалт, хуулиар тогтоосон худалдан авах ажиллагааны үе шат, дарааллыг баримталж ажилласан эсэхийг шалгаж үзлээ.

Аудитад хамрагдсан 19 байгууллагаас 16 байгууллага нь худалдан авах ажиллагаа тус бүрт тендерийн бичиг баримтыг холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж, тендерийн хороогоор

Аудитын дүн

батлуулан, гүйцэтгэгч сонгох ажиллагааг хуулиар тогтоосон үе шат дарааллаар хийж гүйцэтгэсэн байна.

Бусад 3 байгууллагад тендерийн урилгыг зарлан мэдээлэхдээ тендерт оролцогчдын тендер бэлтгэж ирүүлэх хугацааг хуульд заасан хугацаанаас багаар тогтоосон, олон улсын хэмжээнд зарлагдах ёстой тендерийг зөвхөн дотооддоо зарласан, гүйцэтгэгч сонгох ажиллагааны үе шат дарааллыг баримтлаж ажиллаагүй зөрчил илэрсэн байна.

- ГЕГ-аас нээлттэй зарласан 33 тендерийн урилга, бусад материалд тулгуурлан шалгаж үзэхэд шалгалтад хамрагдсан тендерийн материалын 56.8 хувь буюу 25 тендерийн урилгад тендер хүлээж авах эцсийн хугацааг хуульд заасан хэмжээнээс 4 – 25 хоногоор дутуу зарлаж, гүйцэтгэгч сонгох ажиллагааг хэрэгжүүлжээ.

Захиалагч тендерт оролцогчдоос тендерийн материал бэлтгэж ирүүлэх хугацааг багаар тогтоож байгаагаас тендерт оролцохыг сонирхогчдын тендерт оролцох нөхцөл, боломж тэр хэмжээгээр хязгаарлагдаж байна.

- ХХААЯ-наас зарласан 2,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шүлхийн вакцин, оношлуур нийлүүлэх тендерийг хуулийн 15.3-т заасны дагуу тендерийн урилгыг олон улсын хэмжээний эсвэл олон улсын хэл дээр хэвлэгддэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаагүй байна.

Тендер шалгаруулалтын чухал үе шат болох тендерийн бичиг баримтыг бэлтгэх, тендерийн урилгыг зарлан мэдээлэх ажлыг хууль, тогтоомжийн дагуу хийхгүй байгаа нь худалдан авах ажиллагааг цаашид хэвийн явуулах нөхцөл боломжийг алдагдуулснаас гадна худалдан авах ажиллагааны ил тод байх зарчим алдагдахад хүрч байна.

- Шуудан, цахилгаан холбооны газар нийт 14 бараа, ажил үйлчилгээнд нээлттэй тендер зарласнаас 6 тендерийн хороог урилгаа тараасны дараа байгуулсан, тендер хүлээн авах хугацааг хуулийн дагуу зарлаагүй байлаа.

Аудитын явцад тендерийг нээх, үнэлэх, гэрээ байгуулах хүртлэх үйл ажиллагаанд ноцтой зөрчил дутагдал гараагүй байна.

Худалдан авах ажиллагааны тендерийн хороо, үнэлгээний хэсгийн хэлбэр, бүрэлдэхүүнийг хуулийн 38 дугаар зүйлд заасан нөхцөл шалгуурыг харгалзан зохион байгуулсан эсэх болон тендерийн хорооны эрх, үүргийн биелэлтийг холбогдох материалд тулгуурлан шалгалаа.

Хуулийн 38 дугаар зүйлийн 3-т заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг олон хэсэг хувааж яам дундын тендерийн хороогоор шийдвэрлэвэл зохих худалдан

Аудитын дүн

авах ажиллагааг яамны тендерийн хороогоор, яамны тендерийн хороогоор шийдвэрлэвэл зохих худалдан авах ажиллагааг агентлагийн тендерийн хороогоор шийдвэрлэсэн зөрчил нийтлэг байна.

Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад зориулж батлагдсан 250.0 сая төгрөгт багтаан 23.3 сая төгрөгөөр багшийн ширээ, 54.2 сая төгрөгөөр сурагч ширээ сандал, 18.0 сая төгрөгөөр хөгжим, 61.7 сая төгрөгөөр компьютер худалдан авах ажиллагааг яамны тендерийн хороо зохион байгуулж шийдвэрлэсэн байна.
- ГЕГ-ын гаалийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд 2003 онд 500,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар батлагдсанаас тус газар тоног төхөөрөмж, техник хэрэгслийг 18 багц болгон салгаж, тус тусад нь агентлагийн тендерийн хороо зохион байгуулж шийдвэрлэжээ.

Энэ нь хуулийн 9 дүгээр зүйлийн 7-д заасан “Энэ хуулийн 9.6-д заасан тохиолдолд бүх багцын нийлбэр өртгийг үндэслэн гүйцэтгэгч сонгох ажиллагааны журмыг сонгоно” гэсэн заалтыг зөрчжээ.

Зарим худалдан авах ажиллагааны тендерийн хороо хуулийн 40 дүгээр зүйлийн 1-ийн 2-т заасны дагуу үнэлгээний хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэн байв.

Тухайлбал:

- “Нийгмийн эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд зэрэг сурдаг өрхийн хүүхдэд үнэ төлбөргүй олгох хичээлийн хэрэглэл нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгалруулах тендерийн хорооны үнэлгээний хэсгийн гишүүд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй “Алтан жолоо” ХХК-ийг тендерт шалгаруулахаар санал оруулж ирсэн байхад тендерийн хороо эрх, үүргээ хэрэгжүүлэлгүйгээр уг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрхийг захиалагчид албан ёсоор тавьж, шийдвэрлүүлсэн байна.

Тендерийн хороо, үнэлгээний хэсгийг гүйцэтгэгч сонгох ажиллагаа тус бүрд шинээр байгуулахгүй, өмнө байгуулсан тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүд өөр бусад худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал:

- Багануур ХК тендерийн хороо, үнэлгээний хэсгийг 2001 оны 12 сард Төлөөлөн удирдах зөвлөлийн

Аудитын дүн

хурлын шийдвэрээр байнгын ажиллагаатайгаар байгуулж, өнөөг хүртэл худалдан авах ажиллагааг энэ тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүд хэрэгжүүлж байна.

Энэ нь хуулийн 38 дугаар зүйлийн 5-д “Тендерийн хороо нь байнгын бус ажиллагаатай байх ба энэ хуулийн дагуу тухайн гүйцэтгэгч сонгох ажиллагааг зохион байгуулах зорилгоор байгуулагдана.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Тендерийн хороо, үнэлгээний хэсгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгуулахгүй байгаа нь цаашид худалдан авах ажиллагааг хуулийн дагуу явуулах боломжгүй болгож байна.

Энэ нь захиалагч байгууллагуудын удирдлага болон худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудын энэ талын хууль, эрх зүйн мэдлэг чадвар хангалтгүй, санаачлага муутай ажилласнаас шалтгаалжээ.

Тендерийн бичиг баримтыг үнэлж худалдсаны орлого, зарцуулалтын байдлыг холбогдох материалд тулгуурлан шалгалаа.

Хуулийн 16 дугаар зүйлийн 2-д зааснаар захиалагч тендерийн бичиг баримтыг бэлтгэхэд зарцуулсан **өртгөөр үнэлж**, тендерт оролцохыг сонирхогчдод **уг үнээр** саадгүй олгох ёстой.

Аудитад хамрагдсан байгууллагууд 2003 онд тендерийн баримт бичгийг үнэлж худалдан 95.1 сая төгрөгийн орлого хуримтлуулжээ.

Үүнээс аудитад хамрагдсан 8 байгууллага 28.3 сая төгрөгийн төлбөр тооцоог худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнаар дамжуулан ямар нэг данс бүртгэлд тусгалгүйгээр бэлэн мөнгөөр гүйцэтгэжээ.


Аудитад хамрагдсан байгууллагууд тендерийн бичиг баримтыг үнэлж худалдсаны орлогыг хууль бусаар тендерийн хорооны дарга, гишүүдийн ам шийдвэрээр зарцуулжээ.

Тендерийн бичиг баримтыг үнэлж худалдсаны нийт орлогын 36.3 хувь буюу 34.5 сая төгрөгийг тендерийн хороо, үнэлгээний комиссын гишүүдийн урамшуулалд, 4.2 хувь буюу 4.0 сая төгрөгийг тендерийн хороо, үнэлгээний комиссийн гишүүдийг хооллох, дайлах зардалд, 0.6 хувь буюу 0.6 сая төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд тус тус зарцуулсан байна.

Худалдан авах зарим ажиллагааг хэрэгжүүлсэн тендерийн үнэлгээний хэсэг нь тендерт ирүүлсэн материалуудын үнэлгээг Улаанбаатар хотын ойролцоох амралтын газарт очиж хийжээ.

Аудитын дүн

Тухайлбал: Шуудан, цахилгаан холбооны газраас зарласан Говь-Алтай, Завханы чиглэлийн агаарын шилэн кабелийн ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа Баянтуул амралтанд очиж үнэлгээ хийхэд 310,0 мянган төгрөг зарцуулжээ.



Дээрх байдлаас үзэхэд тендерийн бичиг баримтыг бэлтгэхэд зарцуулсан өртгөөр үнэлж, тендерт оролцохыг сонирхогчдод уг үнээр саадгүй олгоно гэсэн хуулийн заалт зөрчигджээ.

Тендерийн бичиг баримтыг бэлтгэхэд зарцуулсан өртөгт тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүд өөрсдөө авах урамшуулал, хоол, амралт, бэлэг дурсгалын зүйлийн үнэ зэрэг тендерийн бичиг баримтыг бэлтгэхэд огт хамааралгүй зардлуудыг оруулан тооцож байгаагаас үзэхэд тендерийн бичиг баримтыг үндэслэлгүйгээр илүү өндөр үнээр үнэлж, тендерт оролцогчдыг хохироосон байна.

Энэ байдалд тендерийн бичиг баримтыг хэрхэн үнэлэх, түүнийг бэлтгэхэд зарцуулсан өртөгт ямар зардлуудыг хамруулах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь нөлөөлсний гадна тендерийн хороодын дарга, захиалагч байгууллагуудын удирдлага болон худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудын хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.

Тендерийн бичиг баримтыг үндэслэлгүйгээр өндөр үнээр үнэлж, тендерт оролцогчдоос хууль бусаар илүү олсон орлогоос аудитад хамрагдсан худалдан авах ажиллагааны тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүд хоорондоо зөвшилцөж 34.5 сая төгрөгийг урамшуулал нэрээр хувааж авсан байна.

Дээрх тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүд нь тухайн

Аудитын дүн

худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг хууль, тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид юм.

Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй биелүүлж өндөр амжилт гаргасан, онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсний төлөө мөнгөн урамшил олгож болохоос гадна энэ урамшил шагналыг тодорхой эрх бүхий байгууллага, албан тушаалтны албан ёсны шийдвэрээр олгох ёстой.

Авилгалын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 2-т заасны дагуу төрийн захиргааны, улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчид албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс бэлэг, мөнгөн шагнал, шан харамж авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэхийг хориглосон байдаг.

Тусгай журмын 9 дүгээр бүлэгт зааснаар захиалагч байгууллага худалдан авах ажиллагаа тус бүрт бичиг баримтын бүрдлийн хавтаст хэрэг нээж, хөтлөн архивын нэгж болгон хадгалсан байх ёстой.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 89.5 хувь буюу 17 байгууллага худалдан авах ажиллагаа тус бүрт тусгай журмын 99 дүгээр зүйлд заасан бүрдлээр хавтаст хэрэг нээж хөтлөн архивын нэгж болгон хадгалаагүй, зарим худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг хагас дутуу бүрдүүлсэн байна.

Худалдан авах ажиллагаа хариуцсан зарим ажилтнууд Тусгай журмын 99 дүгээр зүйлд заасан баримт бичгүүдийг худалдан авах ажиллагаа тус бүрээр бүрдүүлж, хавтаст хэрэг нээж хөтлөөгүйгээс зарим худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгүүд эмх цэгц муутай байсан нь шалгалтын явцад хүндрэл учруулж, худалдан авах ажиллагаатай холбоотой тоо, мэдээ гаргуулах ажил удааширч, аудит хийх хугацааг хойшлуулах шалтгаан боллоо.

Энэ нь захиалагч байгууллагын удирдлага болон худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд ажилдаа хариуцлагагүй хандсанаас шалтгаалсан байна.

Төсвийн
хөрөнгийн
зарцуулалтад
арвилан
хэмнэлт, үр
ашиг, ил тод

Аудитад хамрагдсан байгууллагууд тухайн жилийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас зардлын хэтрэлт, хэмнэлтийг тооцож гаргахаар хязгаарлагдаж, худалдан авах ажиллагаа тус бүрээр худалдан авалтын үр ашгийг тооцож үздэггүй байна.

Улсын төсвийн урсгал болон үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг худалдан авах ажиллагаа тус бүрээр нарийн

Аудитын дүн

байдал бий болсон эсэх

төлөвлөхгүй байгаа тул худалдан авах ажиллагааны хэмнэлт, хэтрэлтийг худалдан авах ажиллагаа тус бүрээр тооцож, нэгтгэх боломжгүй байна.

Энэ нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг нэр төрөл тус бүрээр нь нэгтгэж, шинжилгээ дүгнэлт хийдэггүйтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг тус бүрээр нь нарийн төлөвлөсөн байдаг тул аудитад хамрагдсан зарим байгууллагын худалдан авах ажиллагааны хэмнэлт, үр ашгийг 2003 оны төсвийн тухай хуулиар баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг үндэслэн тооцож үзэхэд:

- БСШУЯ-нд 2003 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 24 төсөл арга хэмжээнд 2150.1 сая төгрөг батлагдаж, уг хэмжээг 24 байгууллагатай 2354.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 204.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
- Багануур ХК-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталсан 2003 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 24 төсөл, арга хэмжээнд 6294.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 16 төсөл арга хэмжээнд 5861.2 сая төгрөг зарцуулжээ. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 433.2 сая төгрөгөөр хэмнэсэн мэт харагдаж байгаа боловч энэ нь нийт төлөвлөж байсан төсөл, арга хэмжээний 33.3 хувийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ тус бүрээр авч үзвэл 100 тн-ын даацтай өөрөө буулгагч автомашин худалдан авах, алхагч эксковаторын үндсэн эд анги солих их засварын ажил, зам услагч автомашин худалдан авах, УАЗ-2206 маркийн фургон автомашин худалдан авахад нийт 3324.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 3872.2 сая төгрөг зарцуулан батлагдсан төлөвлөгөөг 547.8 сая төгрөгөөр хэтрүүлсний гадна ус шүүрүүлэх цооног, коллектор барих, КАТ-777D маркийн автомашины их засварын ажил, барилгын засварын ажил, 25 кг/см² – 30кг/см² хүчин чадалтай даралтын компрессор худалдан авах зэрэг 12 төсөл арга хэмжээнд 2225.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1989.0 зарцуулан батлагдсан төсвийг 236.0 сая төгрөгөөр хэмнэжээ.

Дээрх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээс харахад хэрэгжүүлсэн төсөл, арга

Аудитын дүн

хэмжээний гүйцэтгэл нийт дүнгээрээ батлагдсан хэмжээнээс 311.8 сая төгрөгөөр илүү байгаа нь худалдан авах ажиллагаанд бодит хэмнэлт гарч чадаагүйг харуулж байна.

2003 онд Гаалийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 30 төсөл, арга хэмжээнд 6252.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 26 төсөл арга хэмжээнд 4423.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1828.8 сая төгрөгөөр хэмнэжээ.

Дээрх хэмнэлтэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь нийт төлөвлөж байсан төсөл, арга хэмжээнээс 917.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. Энэ нь нийт хэмнэлтийн 50.1 хувийг эзэлж байна. Үлдсэн хувь нь худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсний дүнд бий болсон хэмнэлт байна.

Аудитын явцад цуглуулсан мэдээлэл, тооцоо судалгаанаас үзэхэд тендер шалгаруулалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж чадсан худалдан авалтад ямар нэг хэмжээгээр хэмнэлт гарч, харин тендер зарлаагүй авсан худалдан авалтад батлагдсан төсвийн хэмжээнд зарцуулах буюу хэтрүүлэн зарцуулах явдал нийтлэг байна.

Тухайлбал: Гэмтэл, согог сэргээн засах эмнэлгийн 2003 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардалд 425.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 507.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 82.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Гэтэл батлагдсан төсвийн 38.8 хувь болох 165.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад нээлттэй тендер зарлаж худалдан авах ажиллагааг хэрэгжүүлснээс 151.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулж 14.0 сая төгрөгийн хэмнэлт гаргажээ. Батлагдсан төсвийн 44,9 хувь болох 190.9 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг тендер зарлалгүйгээр худалдан авснаар гүйцэтгэлээр 356.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 91.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний ашиглалт, үр дүн

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байдлыг холбогдох баримт материалд тулгуурлан шалгаж үзэхэд зарим худалдан авах ажиллагааны явцад гэрээ байгуулах угтвар нөхцөл болох гэрээний гүйцэтгэлийн баталгааг тендерт шалгарсан компаниас гаргуулалгүйгээр гэрээг байгуулсны улмаас гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой зарим зөрчилд захиалагчийн зүгээс гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож чадаагүй байна.

Тухайлбал:

- Багануур ХК-д САТ-777D өөрөө буулгагч автомашинд зориулж “Вагнер – Ази ТТ” ХХК-аас нийлүүлсэн хөдөлгүүрийн зарим эд анги удаа дараалан эвдэрч үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулснаас тус компанид 446.1 сая төгрөгийн

Аудитын дүн

хохирол учруулсан, тус компанид “Азотын бордоо нийлүүлэх” тендерт шалгарсан “Эрчим-концерн” ХХК захиалагчтай байгуулсан гэрээний үүргээ 100 хувь биелүүлээгүй байхад гүйцэтгэгчтэй ямар нэг хариуцлага тооцоогүй байна.

Богд хааны ордон музейн нийтийн бие засах газрын барилгын гүйцэтгэгчийг сонгох тендер зарлан гүйцэтгэгчээр “Дэлгэр ган” ХХК шалгарч гэрээ хийгдсэний дагуу барилгын ажлыг гүйцэтгүүлж зураг төсвийн дагуу бүх ажил хийгдэж дууссан тул комисс томилон шалгаж хүлээн авсан боловч Нийслэлийн дулааны шугам сүлжээний газар шинэ загварын бойлер тавьж түүгээр дамжуулна гэсэн шалтгааны улмаас одоо болтол ашиглагдаагүй байна.

Дээрх байдлаас харахад худалдан авах ажиллагааны явцад хийгдсэн гэрээний үүргийн биелэлтийг холбогдох хууль, эрхийн актын дагуу нарийн тооцохгүй байгаагаас захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж, худалдан авах ажиллагааны эцсийн үр дүн болон захиалагч байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний чанар байдалд хэрхэн хяналт тавьж ажиллаж байгааг аудитад хамрагдсан зарим байгууллагад шалгахад зарим бараанд чанарын хяналт хангалтгүй хийгдэж байгаа нь тогтоогдсон байна.

Тухайлбал:

- Багануур ХК-наас зарласан тендерт шалгарч гэрээний дагуу нийлүүлсэн сэлбэг материалын чанар муу, ашиглалтын наад захын шаардлага хангахгүй байгаа талаархи гомдол, саналыг захиалагчийн зүгээс тендерт шалгарсан “Сайхан халиун трейд”, “Очир-ундраа”, “Бизон трейд”, “Майнинг трейд интернэшнл”, “Комит сервис”, “Эрчим концерн” зэрэг ХХК –уудад удаа дараа албан ёсоор тавьж байснаас үзэхэд худалдан авсан сэлбэг материалын ашиглалт, чанар байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан “Журам шинэчлэх тухай” 2002 оны 183/172 дугаар тушаалын 3 дугаар бүлэгт зааснаар сурах бичиг хэвлэхээр тендерт шалгарсан байгууллага нь хэвлэгдэх сурах бичгийг захиалсан тоо хэмжээгээр хэвлэхийн өмнө сурах бичгийн эхийг тус яаманд ирүүлж холбогдох байгууллага, үнэлгээний комиссоор сурах бичгийн чанар стандарт, эрүүл ахуйн талаар дүгнэлт гаргуулж сурах бичгийг хэвлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.

Сурах бичгийн хэвлэлийн технологийн хяналтыг хэвлэж буй байгууллага дангаараа хариуцахаар заасан байна. Өөрөөр

Аудитын дүн

хэлбэл сурах бичиг бүрэн хэмжээгээр хэвлэгдэн гарсны дараа сурах бичгийн чанар стандарт, эрүүл ахуйн талаар захиалагчийн зүгээс тавих хяналт хийгдээгүй байна.

Гүйцэтгэгч байгууллага сурах бичгийн эхийг зохих технологи, материалаар үйлдвэрлэж байгаа эсэх нь сурах бичгийн эхийг өөрийн үйлдвэр дээр бэлтгэж, жинхэнэ үйлдвэрлэлийг БНХАУ-д явуулж байгаагаас үзэхэд эргэлзээтэй юм.

Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө нь улсын төсвийн орлогод хэрхэн нөлөөлж байгаа байдлыг зарим тендерт шалгарсан компаниудын татварын албанд өгсөн татварын тайлан, мэдээг бараа, ажил, үйлчилгээ нийлүүлж олсон орлоготой тулгах замаар шалгалаа.

Тухайлбал:

- 2003 оны орлогын албан татварын тайлангаар бүтэн жилийн хугацаанд Агт трейд ХХК 207.3 сая, Чинос интернейшнл ХХК 142.8 сая, Баян-Ус ХХК 39.1 сая төгрөгийн татвар ногдох орлоготой гэж тайлагнасан байна. Гэтэл Багануур ХК-д Агт трейд ХХК 407,9 сая, Чинос интернейшнл ХХК 644,1 сая төгрөгийн сэлбэг, Баян-Ус ХХК Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газраас зарласан Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэвэр усны хос шугам, хлоржуулалтын ажлын гүйцэтгэгчээр шалгарч 2003 онд 100.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Агт трейд ХХК 200,6 сая, Чинос интернейшнл ХХК 501,3 сая, Баян-Ус ХХК 60,9 сая төгрөг бүгд 762,0 сая төгрөгийн татвар ногдох орлогыг нуун дарагдуулсан байна. Татвар ногдох энэ орлогоос улсын төсөвт 114,0 сая төгрөгийн орлого оруулах боломжтой байжээ. Дээрх зөрчил нь Нийслэлийн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст хүсэлт тавьж 4 компаний тайлан, тэнцэл, орлогын татварын тайланг гаргуулан авч шалгахад илэрсэн зөрчил юм.

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтээс улсын төсөвт эргэж төлөгдөх ёстой татвар, хураамж болон бусад төлбөр бүрэн хэмжээгээр төвлөрөхгүй байгааг харуулж байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийхэд тендерт оролцогчдын тендерт ирүүлж буй тайлан тэнцэл болон бусад баримт бичгийг баталгаажуулж шалгах ажлыг оромдсоны гадна төсвийн орлогыг бүрэн хурааж чадахгүй байгаа нь худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтыг хариуцсан СЭЗЯ, Захиалагч байгууллагууд болон гааль, татварын байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаатай холбоотой

Аудитын дүн

байна.

Хуулийн хэрэгжилтэд тавьж буй хяналт болон өмнөх шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлтийг шалгасан тухай

Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах, худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг СЭЗЯ-нд даалгажээ.

Энэ ажлыг тус яамны Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтэс хариуцан ажиллаж байна.

Тус хэлтэс Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны “Яамны газар, хэлтсийн эрхлэх ажил, үүргийн хуваарийг шинэчлэн батлах тухай” 407 дугаар тушаалаар Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогын хэрэгжилтийн талаар гаргасан дараахь ажил үүргийг хариуцан гүйцэтгэж байна.

- Худалдан авах ажиллагааны хууль, түүнийг дагалдан гарсан эрх зүйн баримт бичиг, заавар, журам, тендерийн жишиг бичиг баримтыг улсын хэмжээнд нэгдсэн журмаар мөрдүүлэх, холбогдох байгууллага, ажилтнуудад мэргэжил, арга зүйн сургалт зохион байгуулах
- Улсын хэмжээнд зарлагын удирдлагыг сайжруулах, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулах, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, түүнд олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бие даасан цахим нэрийн (вэб) хуудсыг нээж ажиллуулах, түүний мэдээллийг байнга шинэчлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх зэрэг болно.

Аудитын явцад гарсан зөрчил дутагдал, хуулийн хэрэгжилтийн явц байдлаас харахад дээрх ажил үүргүүд бүрэн хэмжээнд биелэгдээгүй байна.

Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй хэлтсийн дарга нь яам дундын тендерийн хорооны дарга, СЭЗЯ-ны төрийн нарийн бичгийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулж түүний хяналтанд ажиллаж байгаа нь хэлтсийн зүгээс яам дундын тендерийн хорооны даргад хяналт тавих боломжгүй болгож байна.

Тус хэлтсийн мэргэжилтнүүдээс яам дундын тендерийн үнэлгээний хэсэгт оруулан томилж байгаа нь сонирхлын

Аудитын дүн

зөрчилтэй байдлыг бий болгож байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2002 оны 90 дүгээр захирамжийг үндэслэн ажлын хэсэг байгуулагдаж хуулийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргасан байна. Энэ шалгалтаар зохих шатны тендерийн хороо байгуулдаггүй, тендерийн хороо, үнэлгээний хэсгийг хугацаанд нь байгуулаагүй, хуулинд заасан аргыг буруу хэрэглэсэн, нээлттэй тендер шалгаруулалт болон зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгч сонгох ажиллагааны зарыг өдөр тутмын сонинд нийтлээгүй, тендер хүлээн авах эцсийн хугацааг хуулинд зааснаас багаар тогтоох, үнэлгээг журмын дагуу явуулаагүй, бараа, ажлын тендерийн үнэлгээнд онооны систем ашигласнаас гадна шалгалтанд хамрагдсан байгууллагууд 2001-2002 онд 50.1 тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авч хууль зөрчжээ.

Шалгалтын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, буруутай албан тушаалтнуудад зохих хариуцлага тооцож цаашид ийм байдал гаргахгүй байх талаар арга хэмжээ авахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосон байна.

2001 оны төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц, ашиглалт үр дүнд Төрийн хянан шалгах хорооноос(хуучин нэрээр) хийсэн шалгалтаар дээр дурдсан зөрчил дутагдал илэрсэн тул тендерийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах талаар Санхүү эдийн засаг, Дэд бүтэц, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, Гадаад хэргийн сайд нарт дараахь зөвлөмж хүргүүлж байсан байна. Үүнд:

- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтын ажлыг сайжруулахын хамт яамны болон яам дундын тендерийн хорооны тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах.
- ❖ Аймаг, нийслэл, агентлагийн тендерийн хорооны эрх хэмжээнд явуулах тендер шалгаруулалтын үйл ажиллагааг яам болон яам дундын тендерийн хороогоор шийдвэрлэж байгаа явдлыг зогсоож аймаг, нийслэл, агентлагийн тендерийн хорооны эрх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх.
- ❖ Аймаг, нийслэл, агентлагийн тендерийн хорооноос зохион байгуулагдах бараа, үйлчилгээ, ажлын төсөвт өртгийн босго үнийг өсгөх замаар орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох ажиллагаанд аймаг, нийслэл, агентлагийн тендерийн хорооны оролцоог нэмэгдүүлэх боломжийг судлаж шийдвэрлүүлэх.

Аудитын дүн

- ❖ Тендерт оролцогчдын тендерийн материал бэлтгэж ирүүлэх хугацааг хуульд заасан хэмжээнээс багаар тогтоож байгаа дутагдлыг арилгаж, тэднийг тендерт өрсөлдөх тэгш боломжоор хангах арга хэмжээ авах.
- ❖ Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, үе шатны ажлуудыг хуулиар тогтоосон дарааллын дагуу хийж, тендерийн хорооны хэлбэр, бүрэлдэхүүнийг бараа, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журмын 7 дугаар хавсралтын дагуу байгуулж хэвшүүлэх.

Дүгнэлт

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, дүн шинжилгээнд тулгуурлан дараахь дүгнэлт хийж байна.

Тендерийн хуулийн хэрэгжилтийн талаар өмнө хийгдсэн шалгалтуудаар илэрсэн зөрчил дутагдал давтагдсаар байхад холбогдох байгууллага, албан тушаалтнууд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байна.

- Захиалагч байгууллагууд тайлант онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний батлагдсан төсөвтэй уялдуулан худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгээгүйн дээр худалдан авах ажиллагааны явцын тайланг гаргаж, баталгаажуулаагүй байна. Энэ нь худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтнуудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой юм.
- Тендерийн хороо, үнэлгээний хэсгийг зохион байгуулах, худалдан авах ажиллагааны журмыг сонгох, тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх болон худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалын хадгалалт, хамгаалалт холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдэхгүй байгаа нь худалдан авах ажиллагааг цаашид хууль тогтоомжийн дагуу явуулах нөхцөл боломжийг алдагдуулж байна.
- Улсын төсвийн урсгал болон үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг худалдан авах ажиллагаа тус бүрээр төлөвлөхгүй байгаатай холбоотойгоор төсвийн хөрөнгөнд хэмнэлт, хэтрэлт гарсан эсэхийг худалдан авах ажиллагаа тус бүрээр тооцож, нэгтгэх боломжгүй байна.
- Худалдан авах гэрээний үүргийн биелэлтийг холбогдох хууль, эрхийн актын дагуу нарийн тооцохгүй байгаагаас захиалагч, гүйцэтгэгч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн гадна худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний чанар, ашиглалтын байдалд тавих хяналт хангалтгүй байгаа нь худалдан авах ажиллагааны эцсийн үр дүнд сэргээр нөлөөлж байна.

Холбогдох байгууллагын санал

Санхүү, эдийн
засгийн яамны
санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ**

210648 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 32-02-47. E-mail: ulaan@pmis.mof.gov.mn
http://www.mof.gov.mn

2004.07.26 № 1-6/2439
танай _____-ны № _____-т

Санал өгөх тухай

Үндэсний аудитын газраас тендерийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэнд Улсын Их Хурлын төсвийн байнгын хорооны 2002 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 9/7299 тоот албан бичгийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнтэй танилцлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах явцад гарсан нийтлэг зөрчил, дутагдал, тухайлбал, худалдан авах ажиллагааны аргыг оновчтой сонгох, гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааны явцад процессийн шинж чанартай алдаа дутагдал гаргах, эсхүл худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зэрэг нь худалдан авах ажиллагааг зохион байгуулж буй бүх шатны захиалагч байгууллагуудад нийтлэг байгаа гэдэгтэй санал нэг байна.

Үндэсний аудитын газраас хийсэн энэхүү гүйцэтгэлийн аудитын эцсийн зорилго нь Засгийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулснаар ямар үр ашиг, үр дүнд хүрсэн, өөрөөр хэлбэл улсын төсөвт тусгагдсан хэдий хэмжээний хөрөнгийг хэрхэн хэмнэсэн, ямар зүйлд зарцуулсаныг дүгнэхэд чиглэгдсэн бол илүү ач холбогдолтой байх байсан болов уу. Гэтэл энэхүү аудит нь үр ашиг, хэмнэлтийг тооцож гаргах боломжгүй гэсэн дүгнэлтийг хийсэн нь гайхаш төрүүлж байна. Уг нь тухайн жилд худалдан авахаар улсын төсөвт хөрөнгийн эх үүсвэр нь тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний дүнг тухайн салбарын хэмжээнд зохион байгуулагдсан сонгон шалгаруулалтын гэрээний дүнтэй уялдуулан харьцуулж үзэхэд л хэмнэгдсэн хөрөнгийн хэмжээ салбараар гарах боломж гэж үзэж байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр тодорхой бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах шийдвэр гарсны дараа түүний гүйцэтгэгчийг сонгох, гэрээ байгуулах хүртэлх ажиллагаанд энэ хуулийг дагаж мөрдөхөөр тусгагдсан болно. Хуулийн энэ заалтыг улсын төсөв, төлөвлөгөөнд тусгагдаж, хөрөнгийн эх үүсвэр нь батлагдсан тодорхой бараа, ажил, үйлчилгээг худалдан авахтай шууд холбож авч үзэх учиртай.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын тухай" хууль тогтоомж,

Тайлбар 1-ийг үзнэ
үү.

08 2058

Холбогдох байгууллагын санал

бүх процедурыг нарийн судалж дүгнэсний дараа тендерийг хянан үзэх, үнэлэх шатанд гарсан зөрчил дутагдал илүү тодорхой байдаг билээ. "Нийгмийн эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд зэрэг сурдаг өрхийн хүүхдэд үнэ төлбөргүй олгох хичээлийн хэрэглэл нийлүүлэх" ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хэсгийн гишүүд шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй "Алтан жолоо" гэгч компанийг шалгаруулахаар санал оруулж ирснийг Тендерийн хороо гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон байна гэжээ. Энэ тохиолдолд тухайн компанийг хасах талаар хуульд заасан тодорхой үндэслэл байгаагүй бол Үнэлгээний хэсгийн санал, дүгнэлтийг Тендерийн хороо өөрчлөн батлах боломжгүй байдаг.

Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т "Тендерийн бичиг баримтыг түүнийг бэлтгэхэд зарцуулсан өртөгөөр үнэлж, тендерт оролцохыг сонирхогчдоод уг үнээр саадгүй олгоно" гэж заасан. Хуулийн энэ заалтад заасан тендерийн бичиг баримтыг Тендерийн үнэлгээний хэсэг боловсруулан, төслийг Тендерийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлж хорооны гишүүдийн зөвшөөрснөөр батлуулдаг журамтай. Тендерийн бичиг баримт боловсруулах үйл ажиллагаанд Үнэлгээний хэсгийн гишүүд, төслийг Тендерийн хороогоор хэлэлцүүлэхэд хорооны гишүүд нилээд цаг зарцуулдаг бөгөөд энэ нь тухайн албан тушаалтны үндсэн үйл ажиллагаанаас гадна хийгддэг тул цагийн хөлсийг олгох эх үүсвэрийг тендерийн бичиг баримт худалдсанаас орсон орлогоос Тухайн тендерийн хорооны даргын зөвшөөрснөөр олгодог. Энэхүү асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулсан журам гаргах шаардлагатай гэдэгтэй санал нэг байна. Төрийн албан хаагчид өөрийн үндсэн ажлаас гадна тендерийн асуудалд оролцох нь цаг хугацаа, ажлын гүйцэтгэлийн хувьд цаг зав барсан асуудал байдаг. Нөгөө талаар тендерийн үйл ажиллагаанд оролцсон асуудлыг тухайн төрийн албан хаагчийн үндсэн ажлын гүйцэтгэлд оруулж тооцдоггүй.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

Хуулийн дагуу тендерийн үнэлгээг Тендерийн хороо биш Үнэлгээний хэсэг хийдэг. Гэтэл аудитын тайланд Тендерийн хороо үнэлгээг хотын ойролцоо амралтын газар очиж хийсэн мэт ташаа мэдээлэл тусгагдсаныг дахин нягтлан үзэхийн хүсье. Тендерийг нээснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерийн үнэлгээний бүх процесс, мэдээлэл нууц байдаг, нөгөөтэйгүүр үнэлгээний хэсгийн гишүүдэд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого их байдагтай холбоотойгоор зарим үед Үнэлгээний хэсгийнхэн хотын ойролцоо газар очиж үнэлгээ хийсэн цөөн тохиолдол байдгийг үгүйсгэхгүй.

Засгийн газрын худалдан авах ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх асуудлыг тус яамны Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтэс хэрэгжүүлж байна. Тус хэлтсийн ажилтнууд нь мэргэжлийн чиглэлийн заавар зөвлөгөөг захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудад тухай бүр нь өгч ажилдаг бөгөөд тус хэлтсийн мэргэжилтэн нарыг тендерийн хороонд томилон оруулсан нэг ч тохиолдол байхгүй байна.

Цаашид "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай" хууль тогтоомжийг

өнөөгийн тавигдаж байгаа нөхцөл, шаардлагад улам бүр нийцүүлэх зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагын зөвлөмжийн дагуу хуулийг цогц байдлаар өөрчлөхөөр төлөвлөж байгааг энэ дашрамд дурьдая.

Энэ бүхнийг аудитын дүгнэлтэд харгалзаж үзэхийг хичээнгүйлэн хүсье.



ӨРӨЙН НАРИЙН БИЧГИЙН

Ч.ХҮРЭЛБААТАР

Холбогдох байгууллагын санал

Үндэсний аудитын газрын тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2-т “аудит хийлгэсэн байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үндэслэлтэй гэж үзвэл тайланд засвар оруулах, үндэслэлгүй гэж үзвэл өөрийн дүгнэлтийг нэмэлт нотлох зүйлээр бататгах арга хэмжээ авах” гэж заасны дагуу дараахь тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1

Аудитын явцад СЭЗЯ-ны Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтсээс “Нийгмийн эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд зэрэг сурдаг өрхийн хүүхдэд үнэ төлбөргүй олгох хичээлийн хэрэглэл нийлүүлэх” гэрээний гүйцэтгэгч сонгосон хавтаст хэргийг худалдан авах ажиллагааны хууль тогтоомжид хэрхэн нийцсэн талаар хянан үзсэн тайланг гаргуулан авсан бөгөөд энэ тайлангийн Тендерийг үнэлэх хэсэг буюу 8 дугаарт “... Энэ багцад дээрхи 5 компани тендерийн материал ирүүлсэн бөгөөд эдгээрээс шаардлагад нийцсэн тендерийн материал нэгч ирүүлээгүй байна. Гэтэл “Алтан жолоо” ХХК-ийг тендерт хамгийн сайн үнэлэгдсэн материал ирүүлсэн гэж үзжээ.” гэж бичсэнийг үндэслэн уг асуудлыг тайланд тусгасан байна.

Тайлбар 2

“Хуулийн дагуу тендерийн үнэлгээг Тендерийн хороо биш Үнэлгээний хэсэг хийдэг”, “СЭЗЯ-ны Худалдан авах бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн нарыг тендерийн хороонд томилон оруулсан тохиолдол байхгүй” гэсэн тайлбаруудыг дахин авч үзээд аудитын тайланд Тендерийн хороо гэж байсныг Тендерийн үнэлгээний хэсэг гэж залруулан орууллаа.

Холбогдох байгууллагын санал

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны санал



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМНЫ БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 315403, Факс: 976-11-318700

2004.02.23 № 2727
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Тендерийн холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Тендертэй холбоотой хууль тогтоомжийг БСШУЯ үндсэнд нь хэрэгжүүлж ажилласан гэж үзэж байна. Гэвч дутагдалтай бүрэн хэрэгжүүлээгүй байгаа зүйлүүд бий. Энэ талаар аудитийн тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжийг зарчмын хувьд зөвшөөрч байна.

Харин зарим дүгнэлт бодит байдалтай нийцэхгүй байгааг анхаарч үзэхийг санал болгож байна.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

1. Тус яамны шууд захиалгаар шинээр барих, өргөтгөх, их засвар хийх барилга байгууламжийн ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай" Монгол улсын хуулийн дагуу тендерийн бичиг баримтыг тухайн барилгын байршил, технологийн онцлог нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулж, тендер зарлах, нээх, дүгнэх хугацаа, тендерийн бичиг баримтыг худалдах үнэ зэргийг хяналтын төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч яам дундын болон тус яамны тендерийн хороогоор хэлэлцүүлэн батлаж, өдөр тутам гардаг тогтмол 3-аас доошгүй хэвлэлд нийтлүүлэн нээлттэй тендерийг зарлан шалгаруулах зарчмыг хатуу баримталж байсан бөгөөд зарлаагүй явуулсан тендер байхгүй болно.

2. Яам дундын болон яамны тендерийг СЭЗЯ, ДБЯ, БСШУЯ, аймгуудын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан сонгон шалгаруулж байгаа бөгөөд тендерийн хорооны болон үнэлгээний хэсгийн томилголт, унааны зардлыг тендерийн бичиг баримт худалдсан мөнгөөр төлж байсан юм. Мөн хугацааг хэмнэх зорилгоор хэд хэдэн барилгын тендерийг багцлан хамтран зарлах тохиолдолд тендерийг дүгнэхэд олон хоног шаардагддаг тул ажлын цагаар дүгнэхэд хүндрэлтэй байдаг бөгөөд ажлын бус цагаар болон амралтын өдөр тендерийг дүгнэх тохиолдол их гардаг тул тендерийн комиссийн гишүүд хоол, цай, томилголын мөнгийг тендер худалдсан мөнгөнөөс зарцуулдаг тохиолдол гарч байсан болно.

3. Тендерийн бичиг баримт бэлтгэх "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай" Монгол улсын хуулийн дагуу тендерийн бичиг баримтыг тухайн барилгын байршил, технологийн онцлог нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулах, тендер оролцогч нарт өгөх барилгын зураг төсвийг хувилах бичгийн цаас, бичгийн хор, цахилгаан эрчим хүч хэргэлсний зардал гэх мэт/ зардлыг тендер худалдахаас өмнө нарийвчлан тооцож гаргах боломжгүй байдаг тул тендер оролцогч нарт тендерийг худалдахаа тендерийн бичиг баримт бэлтгэхэд зарцуулагдах ойролцоо үнээр худалдаж байгаа юм. Дээрхи хуулинд "тендерийн бичиг баримтыг бэлтгэхэд зарцуулсан

Холбогдох байгууллагын санал

өртгөөр үнэлж төндөрт оролцогчдод саадгүй олгоно” гэж заасантай холбогдуулан төндөр бэлтгэх зардалд ямар зардлыг хамааруулах, гарах зардлыг хэрхэн тооцох, түүнийг зарцуулах журам, зааврыг нарийвчлан гаргах шаардлагатай гэсэн саналтай байна.

Тайлбар 4-ийг үзнэ үү


4. Ихэнх тохиолдолд Улсын экспертизээр хянуулж баталгаажуулсан хяналтын төсөвт өртгөөс хямдруулан төндөрт шалгарсан байгууллагуудтай ажил гүйцэтгэх гэрээ хийж байгаа бөгөөд хэмнэсэн мөнгийг СЭЗЯ-ны сайдын тушаал гаргуулан хөрөнгө дутагдаж байгаа барилгад шилжүүлэн санхүүжүүлж байсан болно.

5. БСШУЯ-ны сурах бичгийн төндөрт гадаадын нэгч компанийг шалгаруулаагүй бөгөөд түүний дотор БНХАУ-д хэвлүүлэхтэй холбоотой ямар ч чиглэл өгөөгүй, шийдвэр гаргаагүй болно. Иймд уг асуудлыг яам дундын төндөртэй холбож тавих нь зүйтэй гэсэн саналтай байна.

6. БСШУЯ-наас сурах бичгийн шинэчлэлийг хийж, мөн СЭЗЯ-тай хамтран “Сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх, ашиглах журам” шийнчлэн гаргаж мөрдүүлснээр энэ чиглэлийн ажилд ахиц өөрчлөлт гарч байгааг хэлэх хэрэгтэй. ЭМЯ, УМХА-аар шалгуулж, сурах бичгийг эрүүл ахуйд нийцүүлэх талаар дүгнэлт гаргуулж, зөвлөмж авч ажилласан нь ач холбогдлоо өгч, сүүлийн хоёр жилд эрүүл ахуйд нийцээгүй сурах бичиг хэвлүүлээгүй болно. Иймд тайлангийн 7-р хуудсанд буй дүгнэлтүүдийг анхаарч үзнэ үү.

7. Мөн Яамны төндөр, Яам дундын төндөрийг зааглаж, тус тусад нь аудит хийж байх нь зөв болов уу. “Алтан жолоо” компани шалгарсан эсэх талаар мэдээлэл Яам дундын төндөрийн хороонд байгаа учир энэ талаар тайланд дурдсан асуудлаар СЭЗЯ-наас тодруулах ёстой юм.

Аудитын тайланг сайдад танилцуулж, яамны газар, хэлтсийн дарга нарын зөвлөлөөр хэлэлцүүлэн, авах арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж эхлээд байна.



БОЛОВСРОЛ СОЁЛ ШИН ЖЛЭХ УХААНЫ
ЯАМНЫ ТӨНДРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б. МИШИГЖАВ

Үндэсний аудитын газрын тайлбар

БСШУЯамнаас ирүүлсэн саналд төндөрийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан зарим дүгнэлт бодит байдалтай нийцэхгүй байгаа талаар 7 зүйлийн тайлбар ирүүлжээ.

Дээрх тайлбар нь тайланд тусгагдсан нөхцөл байдал болон дүгнэлттэй уялдаагүй байгаа тул нэг бүрчлэн хариу тайлбар бичих боломжгүй байна.

Тайлбар 3

Тайланд БСШУЯ төндөр шалгаруулалт зарлалгүйгээр төндөр явуулсан тухай үг үсэг байхгүй бөгөөд тайлангийн дүгнэлт хэсэгт “... төндөрийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх болон худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалын хадгалалт хамгаалалт холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэхгүй байгаа нь худалдан авах ажиллагааг цаашид хэвийн явуулах нөхцөл боломжийг алдагдуулж байна” гэсэн байна.

Холбогдох байгууллагын санал

Тайланд дээрх дүгнэлтэд дэмжлэг болох хангалттай баримт нотолгоог дурдсан бөгөөд БСШУЯамтай холбоотой зарим зөрчил дутагдлыг дурдаагүй байна. Тухайлбал:

Үндэсний жүжгийн академик театрын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэхдээ хуулийн 15 дугаар зүйлийн 5-д заасны дагуу тендерийн бичиг баримтын үнэ, тендер нээх хугацааг тендерийн урилгад тусгаагүй байв.

Тайлбар 4

БСШУЯ ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг БНХАУ-д хэвлүүлэх талаар гүйцэтгэгчид ямар нэг чиглэл өгч шийдвэр гаргасан, гадаадын компанийг гүйцэтгэгчээр шалгаруулсан гэж тайланд дурдсан мэтээр тайлбар ирүүлсэн байна. Энэ нь аудитын явцад баримтаар нотлогдсон зарим дутагдал, дүгнэлтийг илт гуйвуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг өөрийн оронд үйлдвэрлэх боломжгүй болгож БНХАУ-д хэвлүүлэхэд хүргэж байгаа нь сурах бичгийг хэвлэх явцад технологийн болон чанар, эрүүл ахуйн хяналт хийгдэггүй, сурах бичгийн эх зохиолыг бэлтгэж бэлэн болгох ажлыг хугацаа алдаж зохион байгуулснаас шалтгаалжээ. Тайлангийн 7 дугаар хуудас

БСШУЯ сурах бичгийн эх бэлтгэх, хэвлүүлэх ажлыг захиалагчийн хувьд гүйцэтгэгч сонгох ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд хяналт тавьж зохион байгуулах үүрэгтэй.

Холбогдох байгууллагын санал

Дэд бүтцийн
яамны санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН САЙД

210816 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 31-06-03, Факс: 31-06-12
E-mail: webmaster@mid.pmis.gov.mn

2004.07.15 № 2/1625
танай 2004.07.05 -ны № 230 -т


Санал өгөх тухай

Төндөрийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар танилцаад дараах саналыг өгч байна. Үүнд:

1. Гүйцэтгэлийн аудитын тайлан нь төндөрийн холбогдолтой хууль тогтоомж, юуны өмнө "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай Монгол Улсын хууль", Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан "Бараа, ажлын гүйцэтгэгч сонгоход баримтлах тусгай журам"-ын заалтуудын хэрэгжилтийг холбогдох гол яамд, төрийн өмчийн хувьцаат болон хувийн хэвшлийн компани, байгууллагад нэгдсэн шалгуур үзүүлэлтээр шалгаж, гүйцэтгэлийн аудитын дүнг зохих стандартын төвшинд анх удаа нэгтгэн гаргаж, чухал зөвлөмж, дүгнэлт агуулсан материал болсон гэж үзэж байна.

2. Тайлангийн "Аудитын дүн"-гийн хэсэгт "Багануур" ХК, Шуудан, цахилгаан холбооны газарт тодорхой нэрийн бараа, ажил, үйлчилгээний төндөрийн гүйцэтгэгч сонгохдоо шууд гэрээ байгуулсан, төндөрийн урилга тарааснаас хойш төндөрийн хороогоо байгуулсан буюу төндөрийн баримт бичиг хүлээн авах хугацааг хуульд заасны дагуу зарлаагүй зэрэг зөрчил, дутагдал, мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн үндэслэл, нэр бүхий гүйцэтгэгчээс нийлүүлсэн барааны чанарын талаар дурдсан санал, дүгнэлтийг хүлээн авч байна.

3. Аудитын тайлангийн ерөнхий дүгнэлтүүд, түүнчлэн холбогдох сайд нарт хандан тайлангийн "Зөвлөмж" хэсгийн нэгдүгээр заалтад тусгасан зөвлөмжүүдтэй санал нэгтэй байна.



САЙД

Handwritten signature

Б.ЖИГЖИД

06-0486

Холбогдох байгууллагын санал

Эрүүл мэндийн
яамны санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 32-28-78, факс: 32-09-16
E-mail: nyamdawa@mohsw.mng.net
http://www.pmis.gov.mn/health

Ажл. 07.01 № 3/2008
танай _____-ны № _____-т

Тайлбар өгөх тухай

Тендерийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайланд дурдсан клиникийн эмнэлгүүд оны эхний 1, 2 саруудад тендергүйгээр эм, худалдан авч байгаа нь жил бүрийн 12 дугаар сард дараа жилийн төсөв батлагддаг, улмаар дээрхи эмнэлгүүдийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг Яам дундын тендерийн хороогоор сонгон шалгаруулдагтай холбоотой. Иймд Санхүү, эдийн засгийн яамны холбогдох албадтай эмийн тендерийг дараа жилийн эхний 2 сарын хэрэгцээг оруулан нийлүүлэлтийг тооцож байх, энэ тохиолдолд санхүүжилтийг хэрхэн зохицуулах асуудлаар ярилцаж байгаа болно.

Тарваган тахлын вакцины тендер 2003 онд хугацаа алдаж зарлагдсан асуудлын хувьд яам тусгайлан авч үзэж "Вакцин, биобэлдмэл, оношлуурыг худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах заавар"-ыг Эрүүл мэндийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 22-ны 19 тоот тушаалаар батлан мөрдүүлсэн. Энэхүү журамд Вакцин, биобэлдмэлийг дагнасан институт, хүрээлэн үйлдвэрлэдэг онцлог болон дархлаажуулах хугацаанаас хамааран вакциныг багцлах замаар хэсэгчлэн тендер зохион байгуулж байхаар заасан. Мөн Халдварт өвчин судлалын төв, Дархлаажуулалтын сангийн зөвлөл, яамны ажил үүргийн хуваарийг тодорхой болгож өгсөн болно.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА *[Signature]* Д.СОДНОМПИЛ

08-2165

Зөвлөмж

Энэхүү аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

Нэг. Санхүү, эдийн засгийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны, Дэд бүтцийн, Эрүүл мэндийн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд нарт:

- Тайлант онд батлагдсан төсөвтэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хуулийн дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны нэр төрөл тус бүрээр төлөвлөх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Худалдан авах ажиллагааны төсөв, гэрээний дүн, гүйцэтгэл, гүйцэтгэгч байгууллагын нэр, гүйцэтгэгч сонгосон арга зэрэг тоо, мэдээллийг агуулсан мэдээллийн сан бий болгох замаар худалдан авах ажиллагааны талаархи мэдээг улсын хэмжээнд нэгтгэн түүнд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Тендерийн бичиг баримтыг үнэлж худалдсанаас орох орлогыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх.
- Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэлд үндэслэн төсвийн хөрөнгийг хэмнэсэн, үр ашигтай зарцуулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний ашиглалт, үр дүнг тогтмол хянаж, зохих арга хэмжээ авч ажиллах

Хоёр. Хүнс, хөдөө аж ахуйн сайдад:

- Байгаль орчны яам, НҮБХХ-ийн “Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой хөгжлийн арга зам” төсөл, Даян дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран байгаль орчинд хор хөнөөл багатай арга замаар хортон мэрэгчдийг устгах арга замыг судалж нэвтрүүлэх

Гурав. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдад:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг БНХАУ-д хэвлүүлж байгааг зогсоож, өөрийн оронд үйлдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хэвлэлтийн явц болон чанарт технологийн болон эрүүл ахуйн хяналт тавьж ажиллах.